



ХЭНТИЙ АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 72

Чингис хот

Зөвлөл байгуулах, журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.е дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.4 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хөгжилд төр, иргэний нийгмийн байгууллага, уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийн тэгш оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлийн уялдаа холбоог хангаж ажиллах үүрэг бүхий аймгийн "Тогтвортой хөгжил-түншлэл" хамтын ажиллагааны зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Салбар зөвлөлийг сумдад байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тус тус даалгасугай.

ДАРГА



Л.БАТСАЙХАН

"ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ТҮНШЛЭЛ" ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- |                       |                |   |   |
|-----------------------|----------------|---|---|
| Зөвлөлийн дарга:      | Г.Хэрлэнчулуун | –   | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн Засаг даргын орлогч                                |
| Нарийн бичгийн дарга: | Ч.Хос-Эрдэнэ   | –   | Аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний тэргүүн  |
| Гишүүд:               | С. Бат-Эрдэнэ  | –   | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга  |
|                       | Д.Баярмаа      | –   | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга |
|                       | Э.Мөнх-Эрдэнэ  | –   | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга                      |
|                       | Г.Лхагвахатан  | –   | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга   |
|                       | Б.Дархантөр    | –   | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга  |
|                       | Ж.Энх-Амгалан  | –   | Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга   |
|                       | Ц.Идэрбат      | –   | Хэрлэн сумын Засаг дарга  |
|                       | Д.Батболд      | –   | Худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын дарга  |
|                       | М.Муста        | –   | "Баавай төгөлтөр" ХХК-ийн захирал   |
| Ц.Болормаа            | –              | "Нөмрөг алтай" ХХК-ийн захирал                    |   |
| Б.Магсаржав           | –              | Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэр ТӨК-ийн захирал |   |

----- \* ----- \* ----- \* -----